

БНХАУ-ЫН НАМ ТӨРИЙН УДИРДЛАГА

Н.Төмөр*

ХКН-ын XVI их хурал 2002 оны 11-р сарын 8-14-нд Бээжин хотноо хуралдаж, хурлаар Намын Төв Хорооны гишүүн 198, орлогч гишүүн 158 хүнийг тус тус сонгожээ. 2002 оны 11-р сарын 15-нд хуралдсан Намын Төв Хорооны Бүгд хурлаар ХКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн даргаар Ху Жиньтао-г, Улс төрийн Товчооны гишүүнээр 24 хүнийг, орлогч гишүүнээр 1 хүнийг, УТТ-ны Байнгын Хорооны гишүүнээр Ху Жиньтао, У Банго, Вэнь Жябао, Жя Чинлинь, Зэн Чинхун, Хуан Жюй, У Гуаньжэн, Ли Чанчунь Луо Гань нарын 9 хүнийг тус тус сонгожээ. Тус Бүгд хурлаар УТТ-ны Байнгын Хорооноос дэвшүүлсэн саналаар ХКН-ын Төв Хорооны Нарийн бичгийн дарга нарын Газрын нарийн бичгийн дарга нарыг болон ХКН-ын Цэргийн Төв Зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүдийг томилох шийдвэр гаргав. ХКН-ын Төв Хорооны Нарийн бичгийн дарга нарын Газрын нарийн бичгийн дарга нар: Зэн Чинхун, Лю Юньшань, Жоу Юнкан, Хэ Гочян, Ван Ган, Шюй Цайхоу, Хэ Юн, ХКН-ын Цэргийн Төв Зөвлөлийн дарга Зян Зэминь, дэд дарга Ху Жиньтао, Го Босюн, Цао Ганчуань, гишүүдэд; Шюй Цайхоу, Лян Гуанле, Ляо Шилун, Ли Жинай нар болно. 2004 оны 9-р сарын 19-нд хуралдсан ХКН-ын Төв Хорооны IV Бүгд хурлаар Ху Жиньтао-г ХКН-ын Цэргийн Төв Зөвлөлийн даргаар, Го Босюн, Цао Ганчуань, Шюй Цайхоу нарыг дэд даргаар, Лян Гуанле, Ли Жинай, Ляо Шилун, Чэнь Биндэ, Чяо Чинчэнь, Жан

Динфа, Жин Жиюань нарыг томилох шийдвэр гаргажээ.

Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (БХАТИХ)-ын Арав дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 2003 оны 3-р сарын 5-18-нд Бээжинд болов. БНХАУ-ын муж, өөртөө засах орон, хот болон Ардын чөлөөлөх армиас сонгогдсон 2983 төлөөлөгчид их хуралд оролцсоноос 70 хувь нь шинээр сонгогджээ.

БХАТИХ-ын Арав дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганаар БНХАУ-ын даргаар Ху Жиньтао, орлогч даргаар Зэн Чинхун нарыг, БНХАУ-ын Цэргийн Төв Зөвлөлийн даргаар Зян Зэманийг, БХАТИХ-ын Байнгын Хорооны даргаар У Банго, дэд даргаар Ван Жаого, Ли Те-ин, Исмаил Аймаг (уйгур үндэстэн), Хэ Лули, Дин Шисунь, Чэн Сывэй, Шюй Жалу, Жян Жэнхуа, Гу Сюйлянь, Реди (төвд үндэстэн), Шэн Хуашэнь, Лу Юншянь, Оюунчимэг (монгол үндэстэн), Хан Чидэ, Фу Тешэнь нарыг; нарийн бичгийн даргаар Шэн Хуаренийг, гишүүнээр 159 хүнийг, Ардын дээд шүүхийн даргаар Сяо Яныг, Ардын дээд прокурорын газрын ерөнхий прокуророор Жа Чуньванийг тус тус сонгожээ.

БХАТИХ-ын Арав дахь удаагийн анхдугаар чуулганы шийдвэрийг үндэслэн БНХАУ-ын даргын зарлигаар Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдаар Вэнь Зябао-г, Ерөнхий сайдын орлогчоор Хуан Жюй, У И, Зэн Пэйян, Хуэй Лянюй нарыг, гишүүнээр Жоу Юнкай, Цао Ганьчуань, Тан Жасюань, Хуа Жяньминь нарыг, Гадаад

* Н.Төмөр. ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

явдлын яамны сайдаар Ли Жаошинийг, Батлан хамгаалах яамны сайдаар Цао Ганьчуанийг, Улсын хөгжил ба өөрчлөлт шинэчлэлийн хорооны даргаар Ма Кай зэрэг 28 яамны сайд, хорооны дарга нарыг томилов.

Хятад Улсын Ардын Улс Төрийн Зөвлөлдөх Зөвлөл (ХУАУТЗЗ)-ийн Арав дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 2003 оны 3-р сарын 3-14-нд Бээжин хотноо болж тус чуулганаар ХУАУТЗЗ-ийн даргаар Жя Чинлинийг, дэд даргаар 24 хүнийг, нарийн бичгийн даргаар 1 хүнийг, Байнгын Хорооны гишүүнээр 299 хүнийг тус тус сонгожээ.

ХКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНХАУ-ын дарга **Жу Жиньтао** 1942 онд Аньхой мужид төрж, 1964 онд ХКН-д элсэн, 1965 онд Бээжингийн Цинхуа их сургуулийг Усны аж ахуйн барилга байгууламжийн мэргэжлээр төгссөн. Тэрээр 1985-1988 онд Гуйжоу мужийн Намын Хорооны дарга, 1988-1992 онд ТӨЗО-ны Намын Хорооны даргаар ажиллаж байсан. 1992-1993 онд ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны Байнгын Хорооны гишүүнээр сонгогдон, Намын Төв Хорооны Нарийн бичгийн дарга нарын Газрын нарийн бичгийн даргаар томилогдон ажилласан. 1993-1998 онд Намын Төв Хорооны УТТ-ны Байнгын Хорооны гишүүнээр сонгогдон, Намын Төв Хорооны Нарийн бичгийн дарга нарын Газрын нарийн бичгийн дарга нарын Газрын нарийн бичгийн дарга, Намын Төв Хорооны дэргэдэх Намын сургуулийн захирлаар томилогдсон. 1998-1999 онд Намын Төв Хорооны УТТ-ны Байнгын Хорооны гишүүн бөгөөд Намын Төв Хорооны Нарийн бичгийн дарга нарын Газрын нарийн бичгийн дарга, БНХАУ-ын дэд дарга, Намын Төв Хорооны дэргэдэх Намын сургуулийн захирал байсан. 1999-2002 онд Намын Төв Хорооны УТТ-ны Байнгын Хорооны гишүүн, Намын Төв Хорооны Нарийн бичгийн дарга нарын Газрын нарийн бичгийн дарга, ХКН-ын Цэргийн Төв Зөвлөлийн дэд дарга, БНХАУ-

ын дэд дарга, БНХАУ-ын Цэргийн Төв Зөвлөлийн дэд дарга, Намын Төв Хорооны дэргэдэх Намын сургуулийн захирлаар тус тус ажиллаж байв. 2002 оны 11-р сард ХКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, 2003 оны 3-р сард БНХАУ-ын дарга, 2004 оны 9-р сард ХКН-ын Цэргийн Төв Зөвлөлийн даргаар тус тус сонгогджээ.

БНХАУ-ын дэд дарга **Зэн Цинхун** 1939 онд Жанши мужид төрж, 1960 онд ХКН-д элсэн, 1958-1963 онд Бээжингийн Аж үйлдвэрийн дээд сургуулийг Авто удирдлагын мэргэжлээр төгссөн. Тэрээр 2003 онд БНХАУ-ын дэд даргаар сонгогдохоос өмнө 1986-1989 онд Шанхай хотын дэд даргаар ажиллаж байсан. 1997-2002 онд ХКН-ын Төв Хорооны УТТ-ны орлогч гишүүнээр сонгогдон, Намын Төв Хорооны Нарийн бичгийн дарга нарын Газрын нарийн бичгийн даргаар томилогдон ажилласан. 2002 оны 11-р сард УТТ-ны Байнгын Хорооны гишүүнээр сонгогдон, Намын Төв Хорооны Нарийн бичгийн дарга нарын Газрын нарийн бичгийн даргаар томилогдон, мөн оны 12-р сард ХКН-ын Төв Хорооны дэргэдэх Намын сургуулийн захирал болсон.

БХАТИХ-ын Байнгын Хорооны дарга **У Банго** 1941 онд Аньхой мужид төрж, 1964 онд ХКН-д элсэн, 1967 онд Бээжингийн Цинхуа их сургуулийг Электрон вакуум тоног төхөөрөмжийн мэргэжлээр төгссөн. Тэрээр 2003 онд БХАТИХ-ын Байнгын Хорооны даргаар сонгогдохоос өмнө 1999-2002 онд ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогчоор ажиллаж байв. 2002 оны 11-р сард ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны Байнгын Хорооны гишүүнээр сонгогдсон.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд **Вэнь Зябао** 1942 онд Тяньжин хотод төрж, 1965 онд ХКН-д элсэн, 1968 онд Бээжингийн Геологийн дээд сургуулийг Геологийн бүтцийн мэргэжлээр төгссөн. Тэрээр 2003 онд БНХАУ-ын Төрийн

Зөвлөлийн Ерөнхий сайдаар томилогдохоос өмнө 1998-2002 онд ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, ХКН-ын Нарийн бичгийн дарга нарын Газрын нарийн бичгийн дарга, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогчоор ажиллаж байсан. 2002 он 11-р сард ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны Байнгын Хорооны гишүүнээр сонгогдсон.

ХУАУТЗЗ-ийн дарга **Жа Чинлинь** 1940 онд Хэбэй мужид төрж, 1959 онд ХКН-ын гишүүнд элсэн, Хэбэй мужийн Аж үйлдвэрийн дээд сургуулийг Цахилгаан тоног төхөөрөмжийн зохион бүтээгч, үйлдвэрлэлийн мэргэжлээр төгссөн. Тэрээр 2003 онд ХУАУТЗЗ-ийн даргаар сонгогдохоос өмнө 1985-1988 онд Фузянь мужийн Намын Хорооны орлогч дарга, 1988-1990 онд мөн мужийн Намын Хорооны орлогч дарга бөгөөд Намын сургуулийн захирал, 1990-1991 онд мөн мужийн Намын Хорооны орлогч дарга, мужийн дэд дарга, мужийн даргын үүргийг гүйцэтгэгч, 1991-1993 онд мөн мужийн Намын Хорооны орлогч дарга, мужийн дарга, 1993-1994 онд мөн мужийн Намын Хорооны дарга, мужийн дарга, 1994-1996 онд тус мужийн Намын

Хорооны дарга, мужийн АТИХ-ын Байнгын Хорооны дарга, 1996-1997 онд Бээжин хотын Намын Хорооны орлогч дарга, хотын дэд дарга, хотын даргын үүрэг гүйцэтгэгч, хотын дарга, 1997-1999 онд ХКН-ын Төв Хорооны УТТ-ны гишүүн, Бээжин хотын Намын Хорооны дарга, хотын дарга, 1999-2002 онд Намын Төв Хорооны УТТ-ны гишүүн, Бээжин хотын Намын Хорооны даргаар ажиллаж байсан. 2002 оны 11-р сард ХКН-ын Төв Хорооны УТТ-ны Байнгын Хорооны гишүүнээр сонгогдсон.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. “ХКН-ын 16-р их хурлын баримт бичгийн эмхэтгэл”, Бээжин, 2002
2. “ХКН-ын 16 дахь удаагийн сонгуулийн Намын Төв Хорооны IV Бүгд хурлын мэдээ”, Бээжин, 2004
3. “БНХАУ-ын БХАТИХ-ын Арав дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганы баримт бичгийн эмхэтгэл”, Бээжин, 2003
4. “ХУАУТЗЗ-ийн Арав дахь сонгуулийн анхдугаар чуулганы баримт бичиг”, Бээжин, 2003